

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 63

Төрийн ордон, Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 18 ДУГААР ТОЙРГИЙН НӨХӨН СОНГУУЛЬД
ТЕХНИК ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ**

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18 дугаар тойротг явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд "New Image Cast" санал тоолох төхөөрөмж хэрэглэхийг тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР